

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2023 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцлээ.

Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хороодын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн зарцуулалтын талаар ажлын хэсгээс тодруулан асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцэх тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.Энх-Амгалан
Б.ЭНХ-АМГАЛАН

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Г.Тэмүүлэн
Г.ТЭМҮҮЛЭН — Г